



# МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1998 оны 3 дугаар  
сарын 03 едөр

Дугвар 1.1.10

Улаанбаатар хот

Албан бус боловсролыг хөгжүүлэх  
үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх  
тухай

Нэг. "Үндэсний хөтөлбөр баталж, төв байгуулах тухай" Монгол улсын Засгийн газрын 1997 оны 116 дугаар тогтоопыг үндэслэн Албан бус боловсролын Гэгээрэл хөгжлийн төвүүдийг нийслэл, дүүргүүдэд 1998 оны хоёрдугаар улиралд багтаан байгуулахыг Нийслэлийн Боловсролын газрын дарга (П.Дорж), дүүргүүдийн засаг дарга нарт тус тус даалгасугай.

Хоёр. Нийслэл, дүүргүүдэд байгуулах Албан бус боловсролын "Гэгээрэл-хөгжлийн төвийн үлгэрчилсэн дүрэм" ийг хавсралт ёсоор баталсугай.

Гурав. Албан бус боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах Нийслэлийн ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагчаар:

1. Я.Мөнжаргал

Нарийн бичгийн даргаар

2. М.Лхан-Аажав

– Нийслэлийн Засаг даргын орлогч

– НЭДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах зохион байгуулагч

Гишүүдэд:

3. Д.Хадхүү

– НЭДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

4. Ц.Болд

– ЗАА-ны Үйлдвэр үйлчилгээний хэлтсийн дарга

5. П.Дорж

– Нийслэлийн боловсролын газрын дарга

6. Д.Баасансүрэн

– Нийслэлийн хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүдийн газрын дарга

7. Б.Лхамсүрэн

– НЭДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн зохион байгуулагч

8. С.Төмөрбаатар

– Хотын боловсрол төвийн арга зүйч

9. Д.Энхтуяа

– Нийслэлийн хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүдийн газрын ажилтан

Дөрөв. Нийслэлд албан бус боловсролын тогтолцоо бүрдүүлж байгаатай холбогдуулан Боловсролын газарт уг асуудал хариуцсан мэргэжилтнийг орон тоогоор авч ажиллуулахыг Боловсролын газрын дарга (П.Дорж)-д зөвшөөрсүгэй.

Тав. Гэгээрэл-хөгжлийн төвүүдэд хүүхэд, залуучуудыг хөгжүүлэх мэргэжил эзэмшиүүлэх, бие даан сурч, амьдрах арга ухаанд сургах олон талт ажлыг зохиож, үр дүнг тооцон ажиллахыг Хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүдийн газар (Д.Баасансүрэн)-т даалгасугай.

184

### Зургаа Дүүргүүдийн Засаг дарга нарт даалгах нь

1. Албан бус боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах комисс томилон ажиллуулж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг шаардагдах хөрөнгийн хамт дүүргийнхээ жил, жилийн төсөв, төлөвлөгөөнд тусган ажилласугай.
2. Албан бус боловсролын Гэгээрэл хөгжлийн төвүүдийг дүрэмд заасны дагуу ажиллуулж, хүн амын боловсролын ерөнхий түвшинг дээшлүүлэх, хөдөлмөр эрхлэх мэргэжлийн чадвар олгох ажлыг сайжруулж, дүүрэг тус бүрийн хүн амын боловсролын индексийг жил бүр тооцоолон дүгнэлт хийж ажилласугай.
3. Албан бус сургалтыг зохион байгуулах, ажлын байр бий болгох, өрхийн орлого нэмэгдүүлэх чиглэлээр төсөл, хөтөлбөрүүд боловсруулан Төрийн ба Төрийн бус байгууллага, аж ахуйн болон гадаад, дотоодын бусад байгууллага, иргэдтэй хамтран хэрэгжүүлэх бүх талын боломжийг өргөн ашиглаж ажилласугай.

### Долоо Хороодын Засаг дарга нарт даалгах нь:

1. Хорооныхоо иргэдийн бичиг үсгийн болон ерөнхий боловсролын түвшин, боловсролын хэрэгцээний судалгааг нарийвчлан гаргаж, бичиг үсэг үл мэдэх явдлыг арилгах, боловсрол нөхөн олгох ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж ажилласугай.
2. Насанд хүрээгүй хүүхдүүд эцэг, эх, асран хамгаалагчдын хараа хяналтаас гарах, сургууль завсардах явдлаас урьдчилан сэргийлэх, учир шалтгааныг зөв тогтоон буруутай этгээдэд зөхих хууль тогтоомжийн хүрээнд хариуцлага хүлээлгэх зэрэг арга хэмжээ авахын зэрэгцээ амьжиргааны түвшин доогуур өрхийн иргэд, хүүхэд, залуучуудад туслах, тэднийг албан бус сургалтанд хамруулах ажлыг тойргийн ЕБС, Гэгээрэл-хөгжлийн төвтэй хамтран зохион байгуулсугай.

Найм Тус захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, гүйцэтгэлийг жил тутам дүгнэж байхыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Ц.Болдсайхан), Нийгмийн бодлогын хэлтэс (Д.Хадхүү)-т тус тус даалгасугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БАГА УЛААНБААТАР  
ХОТЫН ЗАХИРАГЧ

Ж.НАРАНЦАЦРАЛТ

Ийислэлийн Засаг даргын 1998 оны  
9 сарын 10-и тоот захирамжийн хавсралт

## АЛБАН БУС БОЛОВСРОЛЫН ГЭГЭРЭЛ-ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ҮЛГЭРЧИЛСЭН ДҮРЭМ

### Нэг. Зорилго

Гэгээрэл-хөгжлийн төв нь тухайн нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд хүн ам, хүүхэд залуучуудын амьдралын түвшинг ахиулах гол нөхцөл болох боловсрол нөхөн олгох, боловсролын ерөнхий түвшинг дээшлүүлэх, хөгжүүлэх, хөдөлийр эрхээх мэргэжлийн чадвар олгох ажлыг өргөжүүлэх үүрэг бүхий олон талын зорилго, үйл ажиллагаатай албан ёсны боловсролын тогтолцооюс гадуур зохион байгуулагдсан орон нутгийн шинжтэй албан бус сургалт хариуцсан боловсролын байгууллага мөн.

### Хоёр. Гэгээрэл-хөгжлийн төвийн ажиллах зарчим

1. Төв үйл ажиллагаандаа Монгол улсын үндсөн хууль, Боловсролын хууль болон бусад хууль тогтоомжийг удирдлага болгоно
2. Төв нь үйл ажиллагаагаа төрийн ба төрийн бус, сайн дурын бүхий п байгууллагуудтай нягт хамтран ажиллана
3. Бүх үйл ажиллагаа нь нээлттэй, ил тод байна.

### Гурав. Гэгээрэл хөгжлийн төвийн үүрэг

Гэгээрэл хөгжлийн төв дараах үндсэн үүргийг хүлээнэ. Үүнд:

1. Боловсрол олгох, мэргэжил дээшлүүлэх сургалт явуулах
2. Хүн амыг мэдээллээр хангах
3. Хүүхэд, залуучуудыг хөгжүүлэхэд чиглэсэн сөёл хүмүүжлийн ажлуудыг зохион байуулан гэднийг орон нутгийг хөгжүүлэхэд идэвхтэй оролцуулах
4. Торийн ба торийн бус байгууллагын хамтын ажиллагааг зангидан зохицуулах

### Дөрөв. Гэгээрэл хөгжлийн төвийн үйл ажиллагааны хүрээ

1. Боловсрол ба сургалт  
а/. Хүн ам хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүдийн дунд сургалт явуулах. Үүнд. Анхан шатны бичиг үсгийн сургалтаас орчин үеийн дэвшилтэй технологид тулгуурласан мэдэгээрийн чадвар эзэмшүүлэх сургалт, ахуйн боловсрол эзэмшүүлэх сургалт, өрхийн орлогоо нэмэгдүүлэх сургалт, хувь хүний авьяас сонирхлыг дээшилүүлэх сургалт

- 6/ Албан бус боловсролын ба тасралтгүй боловсролын багш бэлтгэх. Үүнд: Тасралтгүй боловсролын хөтөлбөр хэрэгжүүлэх болон үйлдвэр аж ахуйн тазрыг түшиглэн сургалт явуулахад нь шаардлагатай боловсон хүчинээр хангах, тэдийг бэлтгэх сургалт явуулах.

2. Хүн амыг мэдээллээр хангах  
а/ Мэдээллийн алба ажиллуулах. Үүнд.  
Эрүүл аж төрөх ёс, зохистой хооплолт, төр бүл төлөвлөлт, ёсвэр наасны охид, хөвгүүдийг гэр бүлийн амьдралд бэлтгэх, гэр бүлийн харилцаа, эрүүл аж

терөх ёс, газар тариалан, бизнес эрхлэх, сурган, сэтгэл зүйн зөвлөгөөтөө шөхөн, зөвлөмжүүд бөлгүүд, яриа таниулгаар сурталчлах зорог.

### 3. Орон нутгийг хөгжүүлэхэд оролцох

a/ Хүн амын дунд үйл ажиллагаа явуулах. Үүнд:

Олон нийтийн цуглаан, уулзалт, соёл спортын арга хэмжээ зохион байгуулж, хүн ам, хүүхэд залуучуудын идэвхийг өрнүүлж, орон нутгаа хөгжүүлэхэд тэдний идэвхи, санаачилга оролцоог нэмэгдүүлэх.

b/ Хүн амыг хөгжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх. Үүнд:

Хоршоолол, хамтын аж ахуй эрхлэх талаар сургалт явуулах, сургалтын сан, хуримтлал бий болгох хөдөлгөөн өрнүүлэх.

c/ Ирээдүйд чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлэх. Үүнд:

Ирээдүйг харж орон нутаг, хүн амын хөгжлийн хэтийн төлөвийг тодорхойлон гэр бүлээ төлөвлөхэд нь туслах, хүмүүс хамт олонд зорилгоо тодорхойлоход нь туслах.

### 4. Удирдан зангидах

a/ Терийн ба терийн бус сайн дурын байгууллагатай үйл ажиллагаагаа нягт холбоотой явуулах, хүн амын боловсролыг дээшлүүлэх бүхий л үйл ажиллагааг уялдуулан зохицуулж байгууллагуудын ажлын давхардлыг багасгана.

b/ Олон нийтийн болон боловсролын байгууллагатай нягт хамтран ажилаж материалын ба арга зүйн дэмжлэг авч ажиллана.

### Тав. Гэгээрэл хөгжлийн төвийн удирдлага, бүтэц зохион байгуулалт

1. Гэгээрэл хөгжлийн төвийг төрийн болоод төрийн бус байгууллагууд олон нийт ард иргэд хувийн байгууллагуудын үүсгэл санаачилгад тулгуурлан байгуулна.

2. Гэгээрэл хөгжлийн төв нь удирдах зөвлөлтэй байх ба удирдах зөвлөлөөс захирлыг сонгоно. Удирдах зөвлөл дараах бүрэлдэхүүнтэй байна.

a/ Удирдан зохион байгуулах гишүүн

b/ Боловсрол сургалт хариуцсан гишүүн

c/ Мэдээллийн алба хариуцсан гишүүн

d/ Орон нутгийг хөгжүүлэх хөтөлбөр хариуцсан гишүүн

e/ Хүүхэд, залуучуудын хөгжил хариуцсан гишүүн

3. Гэгээрэл хөгжлийн төвд орон тооны бус багш нар, Хүүхэд, залуучууд, эмзгэлчүүдийн асуудал хариуцсан төрийн захиргааны анхан шатны байгууллагын зохион байгуулагчид, сайн дурынхан ажиллана.

4. Гэгээрэл хөгжлийн төв бүрд бүхий л үйл ажиллагааг зохицуулах зохион байгуулагч, арга зүйч ажиллана

5. Гэгээрэл хөгжлийн төв салбаруудтай байж болно.

6. Төвийн үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажил зохион байгуулна.

### Зургаа. Гэгээрэл хөгжлийн төвийн санхүүжилт

1. Гэгээрэл хөгжлийн төв нь орон нутгийн төсөв, хандивын хөрөнгө, гадаад, дотоодын төслийн санхүүжилс.

2. Гэгээрэл хөгжлийн төв нь ашгийн бус байгууллага бөгөөд багш нар, зохион байгуулагчид, сайн дурынхын урамшуулах, сургалтын материалыг бааз болжижүүлэх зорилгоор төлбөртэй үйлчилгээ явуулж болно.